



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/391

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын элсэлтийн шалгалтын бэлтгэл хангах зорилгоор 2026 оны 06 дугаар сарын 15-23-ны өдрүүдэд зохион байгуулсан эрчимжүүлсэн сургалтад хичээл заасан Улаанбаатар хотын ментор багш нарын сургалтын төлбөр болох 40,519,600 (дөчин сая таван зуун арван есөн мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний батлагдсан зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-д зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ